



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

СОЁМБОМ ЭДЭЭ

195 /195/

2021.12.07

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

АГААРЫН ЦЭРГИЙНХЭН АХИЦ ДЭВШИЛТЭЙ БАЙЛАА



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын тайлангийн хуралд ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал, ХШҮГ-ын ахлах мэргэжилтэн хурандаа Тамир, командлалын бүтцийн нэгжийн дарга нар болон Агаарын цэргийн командлалын харьяа ангиудын удирдлага цахимгаар оролцлоо. Тайлангийн хурлын эхэнд Агаарын цэргийн командлагч

хошууч генерал О.Энхбаяр харьяа анги, салбаруудын ололт амжилт, хийж бүтээсэн ажлын тайланг танилцуулав. Тэр бээр энэ үеэр "Бид энэ онд агаарын цэрэг дайны байдлын үед болон тайван цагт байлдааны үүрэг гүйцэтгэх бэлтгэлийг хангахад чиглэсэн удирдлагын чухал баримт бичиг болох 5 төлөвлөгөөг батлууллаа. Тэрчлэн гадаад харилцаанд дэвшил

гарч ОХУ, АНУ-ын өндөр дээд зочид төлөөлөгчид айлчилсан, олон төрлийн шинэ зэвсэглэл, техник хэрэгсэл хүлээн авч ашиглалтад шилжүүлсэн, нисэхийн анги болон тусгай салбарын хэмжээнд анх удаа дайчилгаа, бэлтгэл үүрэгтний сургалт зохион байгуулж, байлдааны буудлага хийсэн, тусгай болон онцгой үүргийн нислэгийн тоо 3,5 дахин өсөж тэдгээрийг осол зөрчилгүй үйлдсэн, баруун бүс нутгийн анги, салбаруудын авто техникт засвар хийж бэлэн байдлыг дээшлүүлсэн, анги, салбаруудад нийт 6,8 тэрбум төгрөгийн барилга бүтээн байгуулалт, засварын ажил

хийгдсэн зэрэг томоохон ажлуудыг өрнүүлж, жилийн гүйцэтгэлийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа бүрэн хангасан" гэдгийг онцлон тэмдэглэв.

Харин ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал ирэх жил болон ойрын жилүүдэд хийгдэх ажлын талаар товч мэдээлэл хийв. Мөн "2021 он Зэвсэгт хүчний Агаарын цэрэгт шинийг бүтээсэн, ахиц дэвшил гарсан он боллоо гэж дүгнээд, хийсэн бүтээснээ баталгаажуулж, хөгжлийн бодлогоо зөв тодорхойлон хамтдаа урагшлахыг хүссэн юм.



1936 он.

ЦЯЯ-ны сайдын 177 дугаар тушаалаар уурын ттэрэгний техникийг бэлтгэх 15 хүн бүхий сургуулийг нээв.

1962 он.

АИХ-ын 209 тоот зарлигаар Бүх цэргийн дуу бүжгийн чуулга Цэргийн гавьяаны одонгоор шагнагдав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-4	-23

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,855.0
EUR	3,228.0	3,235.0
CNY	447.0	448.0
RUB	39.20	39.60
JPY	25.05	25.15
KRW	2.40	2.41

ЗУРХАЙ

2021.12.07 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 03/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ЕСӨН УЛААН ШАРАГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:
Бие эрхтний хүч сайжирна
Наран ургах, шингэх:
08.27-17.00
Барилдлага:
Түлэх
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй
Суудал:
Уул

Аргын тооллын 12 сарын 7, Ангараг гараг. Билгийн тооллын 4, Элдэв тэнгэртэн одтой, шарагчин үхэр өдөр. Өдрийн наран 8 цаг 27 минутад мандан, 17 цаг 00 минутад жаргана. Тухайн өдөр могой жилтнээ аливааүйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеээнхрийлүүштэй.

Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, хишиг даллага дуудуулах, насан бүтээлхийлгээх, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Эрдэнийг гадагш өгөхөд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсоод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Их цасан буухулрал (7 цаг 03 мин)-д эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

КЛИНИКИЙН ПРОФЕССОР ЦОЛ ОЛГОЛОО

Цэргийн төв эмнэлгийн Эрдмийн зөвлөлөөс эмнэлгийнхээ түүхт 100 жилийн ойгоор анх удаа Клиникийн профессор цолыг олголоо. Тодруулбал, тус эмнэлгийн Мэдрэлийн эмнэл зүйн төвийн мэдрэлийн тасгийн их эмч Н.Дарьсүрэнгийн олон жил хичээл зүтгэл, үр бүтээлтэй ажилласныг үнэлж түүнд эл хүндтэй цолыг олгосон юм.

Тус цолыг хүртэх шалгуур үзүүлэлт нь мэргэжлээрээ 15-аас дээш жил, мэргэжлийн ахлах, тэргүүлэх зэрэг хамгаалаад тав болон түүнээс дээш жил ажилласан, магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, сүүлийн гурван жил тухайн эмнэлэгтээ эмч, эмнэлгийн мэргэжилтнээр ажилласан, эрдэм шинжилгээний өгүүлэл тав, илтгэл 10-аас доошгүйг нийтлүүлж хэлэлцүүлсэн, ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл нэгээс цөөнгүйг туурвисан, оношилгоо, эмчилгээний шинэ арга, патент, ШБОС нэвтрүүлсэн байх, резидентийн сургалтыг

гурваас доошгүй жил удирдсан байх зэрэг шалгуур үзүүлэлтийг хангасан байх ёстой аж.

Энэ үеэр клиникийн профессор Н.Дарьсүрэн хэлэхдээ "Би Анагаах ухааны их сургуулийг 2002 онд төгссөн даруйдаа Цэргийн төв эмнэлгийн Яаралтай тусламжийн тасагт дуудлагын эмчээр анх ажлын гараагаа эхэлж байлаа. Өнөөдөр энэ эмнэлэгтээ 19 дэх жилдээ Монгол Улсын ахлах зэрэгтэй эмч болтлоо ажиллаж байна. Би хамт олноороо маш их бахархдаг. Энэ цолыг авсан гол шалгуур үзүүлэлт нь миний ажлын үр дүн юм болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл миний бие 10 гаруй жилийн хугацаанд АШУУИС болон "Энэрэл" их сургуулийн оюутнуудыг дадлагажуулан ажиллуулан лекц, дадлагын хичээлийг удирдаж, олон мундаг резидент эмчийг энэ салбарт бэлтгэхэд хувь нэмрээ оруулсан гэж боддог. Эцэст нь хэлэхэд гэр бүл, хамт олондоо баярласан сэтгэгдлээ илэрхийлье" гэв.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
373,666 +139

ЭДГЭРСЭН
538,288

НАС БАРСАН
1,942 +3

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6568 +110

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
55

ЭДГЭРСЭН
6386

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 265,423,384

Эдгэрсэн
Нийт: 238,491,434

Нас барсан
Нийт: 5,248,669

цаг үе, үйл явдал

ХАМТАРСАН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



ҮБХИС нь Америкийн Монгол судлалын төвтэй байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд энэ сарын 1-3-ны өдрүүдэд "Эрдэм шинжилгээний бичвэр, бүтээл бичих" сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтад ҮБХИС-ийн 30 гаруй багш, судлаач хамрагдсан юм. Сургалтын чиглүүлэгч багшаар МУИС-ийн багш, доктор Д.Баярсайхан, Үндэсний геологийн албаны дэд дарга, доктор Б.Уянга, Америкийн Монгол судлалын төвийн АНУ дахь салбарын захирал Б.Наранцогт нар ажилласан бөгөөд лекц, семинар, ганцаарчилсан зөвлөгөө гэсэн төрлөөр ZOOM программаар явууллаа.

Оксфордын их сургуулийн доктор Д.Баярсайхан "Судалгаа хийхэд анхаарах зүйлс", Харвардын их сургуулийн доктор Б.Уянга "Байгалийн шинжлэх ухааны бичвэр", Темпл их сургуулийн магистр Б.Наранцогт "Англи хэлний дүрмийн тухай" сэдвээр тус тус

хичээл зааж, судалгаа шинжилгээний арга зүй, туршлагаасаа хуваалцав.

Сургалтад оролцогчдод чиглүүлэгч багш нар өөрсдийн олж авсан өргөн мэдлэг, туршлагаасаа хуваалцаж багш судлаачдын судалгааны ажилд тулгамдаж буй асуудлыг хамтдаа ярилцаж шийдвэрлэх гарцыг эрэлхийлсэн өгөөж, үр дүн өндөртэй сургалт болсон юм.

Сургалтын төгсгөлд ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захирал хурандаа Б.Өлзийхуяг, Америкийн Монгол судлалын төвийн гүйцэтгэх захирал, доктор М.Болорцэцэг нар хаалтын үг хэлж, оролцогчдын санал сэтгэгдлийг сонсон цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

ҮБХИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

"ЗОВОХ ЦАГТ НӨХРИЙН ЧАНАР ТАНИГДАНА" НОМЫН НЭЭЛТ БОЛЛОО



Энэ онд ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, БНМАУ-ын баатар, ЗХУ-ын маршал Г.К.Жуковын мэндэлсний 125 жилийн ой тохиож байна. Энэ хүрээнд Улаанбаатар хот дахь Оросын шинжлэх ухаан, соёлын төвд "Ялалтын маршал Г.К.Жуков" үзэсгэлэн, "Зовох цагт нөхрийн чанар танигдана" хүүхдийн үлгэрийн номын нээлтийн үйл ажиллагаа өчигдөр боллоо. Тус арга хэмжээнд БНМАУ, ЗХУ-ын баатар, сансрын нисэгч хошууч генерал Ж.Гүррагчаа, Монгол цэргийн музейн захирал хурандаа Д.Ганзориг, ОХУ-ын "Россотрудничество" агентлагийн Монгол Улсын төлөөлөгчийн газрын тэргүүн, Улаанбаатар хот дахь "Русский дом"-ын захирал Амгалан Ринчинович Базархандаев, ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны цэрэг, агаарын цэргийн аташе Павел Григорьевич Анисов, БНБУ (Беларусь)-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Дмитрий Николаевич Горелик, Өргөмжит консул Леонид Яковлевич Слободский, ОХУ-аас Монгол Улсад суугаа

Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга Кравцов Максим Владимирович нарын хүндэт зочид уригдан оролцсон юм.

Энэ үеэр Г.К.Жуковын дурсгалын музейн эрхлэгч хошууч Д.Амартайван "Бид энэ жил Монгол, Орос хоёр орны дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн арга хэмжээг хоёр улсын Засгийн газрын түвшинд ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлж байна. Үүний хүрээнд олон сайхан арга хэмжээ зохион байгуулагдаж байгаа нь өнөөдрийн энэ үйл ажиллагаагаар үргэлжилж байна. Музей бол хүүхэд залууст түүхийн талаар үнэн бодит сурталчилгаа, таниулга хийдэг боловсролын байгууллага юм. Иймээс миний бие ч мөн адил Оросын ард түмний тусламж, дэмжлэг манай орны тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдалд хэрхэн нөлөөлсөн талаар ном гаргаа гэсэн сэтгэлээр хандсан. "Зовох цагт нөхрийн чанар танигдана" ном нь үлгэр хэдий ч утга санаа нь хоёр орны найрамдалт харилцааны талаар өгүүлж байгаагаараа онцлог юм" гэв.

ЦЭРГИЙН АХМАДУУД СПОРТООР ...



Төв аймгийн 2021 оны Сагсан бөмбөгийн аварга тэмцээн энэ сарын 5-6-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү тэмцээнд бригадын генерал Ч.Сосорбарамар ахлуулсан Төв аймгийн угшилтай, бас амьдарч байсан

цэргийнхэн 50-аас дээш насны ангилалд амжилттай оролцож, хүрэл медаль хүртжээ.

Манай армийн генерал, хурандаа ахмад үеийнхэн маань "Зөв хандлага-Эрүүл мэнд", "Алдрын дайчид", "Армийн андууд" зэргээр спортын баг бүрдүүлэн идэвхтэй дасгал хөдөлгөөнийг хийж, явган аялалд бусдыг уриалан спортын уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцож, хүүхэд залууст эергээр нөлөөлж, нийгэмд үлгэрлэж яваа билээ. Тэд их Жанжны талбай, Цэцэрлэгт хүрээлэн, Баянзүрх дүүргийн спортын талбай тус тус газруудад алхаж, дасгал хөдөлгөөн хийснээр өглөөг утгахыг хэвшил болгоод буй юм.



ОЛС ТАТАЛТААР ...



Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Нэгдүгээр мотобуудлагын ротоос санаачлан энэ сарын 6-ны өдөр зохион байгуулсан ангийн аварга шалгаруулах "Олс таталт"-ын тэмцээнд 8 багийн 70 гаруй тамирчин ур чадвар, авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдлөө. Тэмцээний тэргүүн байрт ахмад Б.Галдан захирагчтай ЗМБР, хоёрдугаар байрт ахмад Ж.Балданжунай захирагчтай 2МБР, гутгаар байрт ахлах дэслэгч Т.Нацагдорж захирагчтай 1МБР-ын баг тамирчид тус тус шалгарав.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам

Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС

"Соёмбо" сонин

"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)